

БАТЛАВ:  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН  
ДАРГА           Ш.НОХОЙЖАВ

**0.4 КВТ-ЫН АГААРЫН ШУГАМЫН ШИНЭЧЛЭЛИЙН АЖИЛ /ХОВД, ЗЭРЭГ СУМ, ХӨНДЛӨН  
БАГ АЖЛЫН БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: **0.4 квт-ын агаарын шугамын шинэчлэл /Ховд, Зэрэг сум Хөндлөн  
баг/**

Тендерийн дугаар: **ХОАОНӨГ/202001060**

**Улаанбаатар хот  
2020 он**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо 2020.06.26

Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогдоос **0.4 квт-ын агаарын шугамын шинэчлэлийн ажил /Ховд, Зэрэг сум Хөндлөн баг/** ажил гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 10.00** цагаас цахим системээр [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 10.20 минутанд** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар  
4 дахар 407 тоот Орон нутгийн өмчийн газрын  
мэргэжилтэн Э.ЦОЛМОН, Утас: 70434401, 88011269  
[www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч</b>          | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>     | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.<br>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                 | 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:<br><br>(а) Үнийн санал;<br>(б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]  |
| <b>4. Тендерийн үнэ</b>                       | 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.<br>4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.<br>4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.  |
| <b>5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b> | 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
  - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцгчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө уtsan холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГОХЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>Тендерийн нэр: <b>0.4 квт-ын агаарын шугамын шинэчлэлийн ажил /Ховд, Зэрэг сум Хөндлөн баг/</b>          Тендерийн дугаар: <b>ХОАОНӨГ/202001060</b>  <b>Санхүүжилтийн эх үүсвэр нь: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт</b>          Батлагдсан төсөвт өртөг: <b>35,000,000 төгрөг</b>          2020 он санхүүжих дүн: <b>35,000,000.00 (гучин таван сая) төгрөг</b>  <b>Ажил гүйцэтгэж дуусах хугацаа нь: 2020 оны 08 дугаар сарын 15-ний өдөр.</b>          Тендерт оролцогч нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасныг хангаж байгаа эсэх талаар дараах материалыг ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар</li> <li>2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний <b>нотариатаар батлуулсан хуулбар, хавсралт болон гэрээний хамт</b></li> <li>3. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй ба Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендер нээсэн өдрийн байдлаар татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг шалгана.</li> <li>4. Нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай тодорхойлолт; <b>Барилгын инженер, Цахилгааны инженер, ХАБЭ-н ажилтан зэрэг инженер ажилчдын НДЭМ-ийн 2020 оны 1-5 дугаар сарыг төлсөн төлөлт ирүүлэх/</b></li> <li>5. Шүүхийн тодорхойлолт;</li> <li>6. Тендерт оролцгчийг төлөөлөх эрх бүхий этгээд төлөөлөх эрхээ бусдад шилжүүлэх бол маягтын дагуу гаргасан итгэмжлэл.</li> <li>7. Харилцагч банкны тодорхойлолт.</li> </ol>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>          Байгууллагын хаяг: <b>Ховд аймгийн орон нутгийн өмчийн газар</b>            Давхар болон өрөөний дугаар: <b>Ховд аймгийн Ховд аймгийн орон нутгийн өмчийн газрын 4 давхар 407 тоот</b></p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:          Огноо: 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдөр. Цаг: 10.00 цаг.</p>
ТОӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:  <b>Ховд аймгийн орон нутгийн өмчийн газар</b>          Давхар болон өрөөний дугаар: <b>Ховд аймгийн Ховд аймгийн орон нутгийн өмчийн газрын 4 давхар 415 тоот.</b>          Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдөр. Цаг: 10.20 минутад.</p>

ТОӨЗ 2.3	Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ. Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна									
ТОӨЗ 3.1 (а)	Үнийн саналыг маягтын дагуу ирүүлнэ.									
ТОӨЗ 3.1 (б)	<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын зураг, төсвийн дагуу тооцсон төсөв зохиож, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна. /Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох программаар гүйцэтгэнэ./</li> <li>- -Ажил гүйцэтгэх үе шатны ажлын хуваарийг баталгаажуулан ирүүлнэ.</li> </ul>									
ТОӨЗ 3.1 (в)	<ul style="list-style-type: none"> <li>- Сүүлийн 1 жил буюу 2019 оны санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх</li> <li>- Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын борлуулалтын орлогын талаарх мэдээлэл ирүүлнэ.</li> <li>- Ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудад хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын талаарх мэдээллийг ирүүлнэ. /Ажил гүйцэтгэсэн гэрээ, хүлээлгэж өгсөн актын хуулбар, захиалгийн тодорхойлолтыг тус тус ирүүлнэ/</li> </ul>									
ТОӨЗ 3.1 (г)	<p>Уг ажлыг гүйцэтгэхэд эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр доорх тусгай зөвшөөрөл шаардлагатай.</p> <p>БА-3.5 Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, дэд станц, түүний тоног төхөөрөмжийн угсралт</p> <p>ЭХЯ-ны ТЗ-2.1 0.4-15кв-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ Дээрхи 2 заалтын аль нэгийг нь хангасан тохиолдолд тусгай зөвшөөрөлийг хангасан гэж үзнэ.</p>									
ТОӨЗ 3.1 (д)	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт ирүүлнэ.									
ТОӨЗ 3.1 (е)	<ul style="list-style-type: none"> <li>- Тендерт оролцогч зөвхөн тухайн ажилд ашиглах зайлшгүй шаардлагатай дараах үндсэн машин механизмуудыг санал болгоно.</li> </ul> <p>Үүнд:</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Тоног төхөөрөмжийн нэр</th> <th>Тоо ширхэг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Үйлчилгээний автомашин</td> <td>1</td> </tr> <tr> <td>2</td> <td>Автокран 5тн</td> <td>1</td> </tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> <li>- Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудын жагсаалт болон техник хэрэгслийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ.</li> </ul>	№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	1	Үйлчилгээний автомашин	1	2	Автокран 5тн	1
№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг								
1	Үйлчилгээний автомашин	1								
2	Автокран 5тн	1								
ТОӨЗ 3.1 (ё)	<ul style="list-style-type: none"> <li>- Голлох инженер, техникийн ажилтнуудын диплом, иргэний үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбаруудыг тус тус ирүүлнэ.</li> </ul>									

	<ul style="list-style-type: none"> <li>- Дараах хүснэгтэд үзүүлсэн голлох болон инженер техникийн ажилтныг зөвхөн тухайн ажилд санал болгож тогтвортой ажиллуулна.</li> </ul>															
	<table border="1"> <thead> <tr> <th>№</th><th>Албан тушаал</th><th>Хүний тоо</th><th>Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага</th><th>Мэргэжил</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1</td><td>Цахилгааны инженер</td><td>1</td><td>2 болон түүнээс дээш жил</td><td>Цахилгааны инженер</td></tr> <tr> <td>2</td><td>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан</td><td>1</td><td>1 болон түүнээс дээш жил</td><td>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан гэрчилгээтэй байна</td></tr> </tbody> </table>	№	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Мэргэжил	1	Цахилгааны инженер	1	2 болон түүнээс дээш жил	Цахилгааны инженер	2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	1	1 болон түүнээс дээш жил	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан гэрчилгээтэй байна
№	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Мэргэжил												
1	Цахилгааны инженер	1	2 болон түүнээс дээш жил	Цахилгааны инженер												
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	1	1 болон түүнээс дээш жил	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан гэрчилгээтэй байна												
ТОӨЗ 3.1 (ж)	Хяналтын төсөвт тусгасан зураг төслийн үнэ 350 000.00 /гурван зуун тавин мянга/ төгрөгийг өөрийн төсөвт нэмж тооцож ирүүлнэ.															
ТОӨЗ 3.1 (з)	<ul style="list-style-type: none"> <li>- Тендерийн баримт бичиг заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг хүлээн зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ.</li> <li>- Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ.</li> <li>- Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан зураг төсөл, техникийн нөхцөлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</li> <li>- Нийгмийн даатгалын газар, харилцагч банк, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон бусад холбогдох байгууллагуудаас лавлагaa авахад татгалзах зүйлгүй тухай албан мэдэгдэл ирүүлнэ.</li> </ul>															
ТОӨЗ 5.1	Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.															

**Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Ховд аймаг Зэрэг сум,, төвийн айл өрхийг „Бетон шонтой 0.4 кв-ын шугам. сип кабелийн ажлын төсөв

## А Ж Л Ы Н Т О О Х Э М Ж Э Э

020/04/02

Д/д	А ж и л б а р ы н    н э р	Хэмжих нэгж	Тоо
<b>01. Цахилгааны ажил</b>			
1	0.4 кВ-ын агаарын шугамын бүрээстэй 3x50+1x54 мм <sup>2</sup> СИП утас завсрлын тулгуурт татах	км	1.60
2	СИП утасны фазын салбарлагч TTD-181 FJ угсрах	ш	4.00
3	6 багцын Хайрцаг угсрах	ш	30.00
4	Шонгийн нүх гараар ухах	м3	12.60
5	Шонгийн бетон суурь цутгах М100	м3	4.50
6	Төмөр бетон тулгуур угсарч босгох.	ширхэг	29.00
<b>99.Хог хаягдалийн дүн</b>			
7	Хог хаягдал	тн	0.00

Ховд аймаг Зэрэг сум,, төвийн айл өрхийг „Бетон шонтой 0.4 кв-ын шугам. сип кабелийн ажлын төсөв  
Барилгын тоосов - 1.0

БАТЛАВ: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ШАРСТАН



## ХОВД ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХХК -ИЙН

### ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

2020 03-22

№

Ховд ЦТС ХХК

- 1 Хэрэглэгчийн нэр хаяг Ховд аймгийн Зэрэг сум
- 2 Хэрэглэгчийн байршил Ховд аймаг Зэрэг сум
- 3 Ажил үйлчилгээний зориулалт Төвлөрсөн эрчим хүчиний хангамж
- 4 Техникийн нөхцөл олгох үндэслэл Зэрэг сумын засаг даргын 2020 оны 02-р сарын 18-ны өдрийн 1/054 тоот хүсэлтийг үндэслэн
- 5 Суурилагдсан хүчин чадал 90 кВА

6 Холбогдох цэг байршил Ховд аймгийн Зэрэг суманд 2020 онд аймгийн болон сумын төсвийн хөрөнгөөр дараах ажлууд хийгдхээр төлөвлөгдсөн тул доорхи техникийн нөхцлийг олгож байна Үүнд:

1 1 Бургасан багийн айл өрхийг цахилгаан эрчим хүчинд холбоод 3ЭРЭГ 35/10 кВ-ын ХХБ-ын Хойд гаргалгаа Бургасан багийг тэжээж байгаа 10 кВ-ын ЦДАШ-ын 5 дахь тулгуураас отплол авч дээд чиглэлд 700 метр газарт 10 кВ-ын ЦДАШ шинээр барьж шугамын төгсгөлд 10/04 кВ-ын 20 кВА чадал бүхий АТП станц барьж станцын 04 кВ- талаас тус бүр 500 метр 04 кВ-ын 2 гаргалгаа гаргаж айл өрхийг холбох

1 2 Мөн гаргалгааны отплол авсан тулгуураас доод чиглэлд 600 метр 10кВ-ын ЦДАШ шинээр барьж шугамын төгсгөлд 10/04 кВ-ын 20 кВА чадалтай АТП станц барьж станцын 04 кВ- талаас 2 гаргалгаа гарган 800 метр 04 кВ-ын шугам барьж айл өрхийг холбох

2 Зэрэг сумын Бураа багийн айл өрхийг цахилгаан эрчим хүчинд холбох: Эхэн багийг тэжээж буй 10кВ-ын ЦДАШ-ын дундын тулгуураас отплол авч 10 кВ-ын ЦДАШ-ыг 250 метрт шинээр барьж шугамын төгсгөлд 10/04 кВ-ын 50 кВА чадал бүхий АТП станц шинээр угсан станцын 04 кВ-талаас хоёр гаргалгаа гарган тус бүр 500 метр 04 кВ-ын СИП шугам угсарч айл өрхийг тэжээх

3 Сумын төв Хөндлөн багийн айл өрхийн цахилгаан хангамжийг сайжруулах шугам сүлжээг шинэчлэх ажлын хүрээнд Хөндлөн баг Эмнэлгээс урагших гэр хороололын агаарын шугамыг 9 метрын бетон тулгуур бүхий СИП 3Х25+1x90 мм –тэй шугамаар солих 04 кВ-ын шугамын ерөнхий тэжээлийг эмнэлгийн дэд станцаас салгаж КТПН-250 кВА станцын 04 кВ талаас шинээр гаргалгаа гарган таслах залгах аппартур, тоолуур хэмжих хэрэгсэлийг байрлуулан холболт хийх

7 Тоолуур Монгол улсын стандарт шаардлагыг хангасан электрон тоолуурыг шинээр баригдсан дэд станцуудын 04 кВ-ын гаргалгаан дээр тавих айл өрхийн тоолуурыг 3,6-р багцлан хайрцагт угсралт бөгөөд сүлжээнд холбохын өмнө Ховд ЦТС ХХК-ын тоолуур хэмжих хэрэгсэлийн лабораторит шалгуулж баталгаажуулсан байх

**8 Тусгай заалтууд** ЦДАШ, дэд станц, кабель шугам, таслах залгах аппартур угсралтын ажлын явцад Ховд ЦТСХХК-ын шугам сүлжээний алба хэрэглэгчдэд үйлчлэх төвийн ажилтнаар хянуулсан байх

**9 Дор дурдсан техникийн даалгавар хууль дүрэм журмыг мөрдөх**

**9.1** Шинээр барих дэд станц ЦДАШ, кабель шугам, цахилгаан тоноглолын угсралтын ажлын зургийг эрх бүхий байгуулгаар хийлгэж экспертизээр батлуулсан байх

**9.2** Шит самбар, барилгын газардуулгыг норм норматив дүрмийн дагуу хийж холбогдох газраар шалгуулж портоколь авсан байх



**9.3** Дэд станц агаарын болон СИП шугамын угсралтын ажлыг мэргэжилийн байгуулгаар аюулгүй ажиллагааны болон техник ашиглалтын дүрмийн дагуу хийж гүйцэтгэх Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн 4-ийн 22-23-р заалт болон Эрчим хүчиний зохицуулах хорооноос баталсан Ховд ЦТС ХХК-ын холболтын зааврын дагуу Ховд ЦТСХХК-н хэрэглэгчдэд үйлчлэх төв Шугам сүлжээний албаар хянуулан протоколь үйлдэн сүлжээнд холбох

**9.4** Хүчдэлийн түвшингийн  $\pm 5\%$  ийн хэлбэлзэлд зохицсон тоноглол суурилуулах

**9.5** Энэхүү техникийн нөхцөлийн дагуу холболтыг 1 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд шугам сүлжээнд холбогдоогүй тохиолдолд хүчингүйд тооцно

**ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОСОН**

Комиссын дарга

 У. Пүрэвдорж Ерөнхий инженер  
Гишшүд  Н. Шинэжил Ерөнхий санхүүч  
 Т. Нармандах Ашиглалтын инженер  
Д. Уртнасан  Борлуулалтын албны дарга  
Н. Ням-Эрдэнэ РХ-ын инженер

### Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

#### Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

- (а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;
- (б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

#### Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

- (а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.
- (б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

#### Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

**Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.**

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(*Захиалагч байгууллагын нэр*)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [*тендерт оролцогчийн нэр*], [*гэрээний нэр ба дугаар*]-ыг [*тендерийн үнийг тоогоор болон үсгээр*] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | <b>1.1.</b> Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.   |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | <b>2.1.</b> Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.  |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | <b>3.1.</b> Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.   |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | <b>4.1.</b> Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br><br><b>4.2.</b> Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гол түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.   |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | <b>5.1.</b> Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй   |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | <b>6.1.</b> Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |
| <b>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b>                    |   |
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>                                    | <b>7.1.</b> Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br><br><b>7.2.</b> Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b>                         | <b>8.1.</b> Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.   |
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>                          | <b>9.1.</b> Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дусах хүртэл сунгана.  |

- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
  - 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардлагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## B. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарыт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
  - 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарыт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## G. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусгахаас өмнө төслийн менежертууд хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер

гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл оөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай

холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

- 20. Гүйцэтгэлээ с чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

## Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар 0.4 квт-н агаарын шугамын шинэчлэл Зэрэг сум, <b>Хөндлөн баг/ ХОАОНӨГ/202001060</b>
<b>ГЕН 2.1</b>	Ажил нь <b>зураг төсөл, ажлын тоо хэмжээнээс</b> бүрдэнэ. Ажлын талбай нь <b>Хөвд аймаг Зэрэг сум</b> байрших болно.
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь: <b>Захиалагч томилно.</b>
<b>ГЕН 4.1</b>	Ажил эхлэх өдөр: <b>Гэрээ байгуулсан өдрөөс тооцно</b> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: <b>2020 оны 08 дугаар сарын 15-ний өдөр.</b>
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <b>14</b> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа 1080 <b>хоног</b> байна.
<b>ГЕН 13.1</b>	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <b>0,05 хувь</b> байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <b>10 хувисас баагауу</b> байна.
<b>ГЕН 17.1</b>	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <b>[огноо]-ны</b> дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг <b>[огноо]-ны</b> дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <b>[мөнгөн дүн]</b> байна.
<b>ГЕН 19.1</b>	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <b>[хувь]-иар тооцно.</b>

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### ЗАХИАЛАГЧ

### ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож  
\_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө,  
бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_  
хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай,  
\_\_\_\_\_  
суурь, \_\_\_\_\_ хана,  
\_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга  
угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг \_\_\_\_\_  
инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/,  
\_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны дугаар  
сарын \_\_\_\_\_ -ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны дугаар сарын \_\_\_\_\_ -ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;

- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.**

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

**6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

**7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

**8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

**9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцаагч банкны нэр, дансны дугаар]

#### **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцаагч банкны нэр, дансны дугаар]